



Тусгай дугаар

ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОЛОО

Өнөөдөр Батлан хамгаалах яамнаа эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь болж, бусад нөхдөө манлайлсан алба хаагчдад цэргийн мэргэжлийн II, III зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгууллаа.

БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын болон ЗХЖШ-ын даргын тушаалаар БХЯ түүний харьяа байгууллагын цэргийн мэргэжлийн бататгах шалгалтад тэнцсэн зарим цэргийн алба хаагчдад БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа цэргийн мэргэжлийн зэргийн үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулан амжилт хүссэн юм.

Энэхүү үйл ажиллагаа нь цэргийн сургалт бэлтгэлийн чанар, алба хаагчдын албандаа хандах хандлага, өөрийгөө хөгжүүлэх идэвх санаачилгыг дээшлүүлэх түүнээс хамааран цалин, нийгмийн хангамжийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнээр хангах зорилготой.

Цэргийн алба хаагч мэргэжлийн зэрэг эзэмшсэн тохиолдолд III зэрэгт 5 хувь, II зэрэг 10 хувь, I зэрэгтэй бол 15 хувиар тооцож үндсэн цалин дээр нэмэгдэл олгогддог.

Алба хаагчид мэргэжлийн



зэрэг эзэмшихийн тулд биеийн тамирын бэлтгэлийн стандартыг хангасан байх, цэргийн сургалт бэлтгэлээр "Сайн"-аас дээш болоод төрийн жинхэнэ албан

хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ "Хангалттай" болон түүнээс дээш байх, цэргийн сургууль, дамжаа төгссөнөөс хойш хоёр ба түүнээс

дээш жил ажилласан офицер, ахлагч, цэргийн гэрээт албанд элсэж нэг ба түүнээс дээш жил алба хаасан цэргийн гэрээт алба хаагчид дээрх үндсэн

шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Мөн Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/75 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Цэргийн мэргэжлийн зэрэг олгох журам"-ын дагуу урьд нь мэргэжлийн зэрэг олгохдоо зөвхөн тухайн алба хаагчийн шалгалтын дүнг үндэслэдэг байсан заалтыг халж нэмэлтээр, шалгалтад орох алба хаагчийн хариуцсан цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбар, алба, тасаг, нэгжийн хувьд сүүлийн хоёр жил ажлын хариуцлага алдаагүй, алба хаагч нь захиргааны болон сахилгын ноцтой зөрчил, дутагдал гаргаагүй байх ёстойг зүйлчилж өгсөн.

Тус заалт нь хариуцсан нэгж нь хангалтгүй дүн үзүүлсэн, алба хаагчид нь сахилгын зөрчил гаргасан тохиолдолд мэргэжлийн зэрэг эзэмшдэг явдлыг халж, таслан зогсоох улмаар цэргийн нэгтгэл, анги, салбар, байгууллагууд хууль, дүрэм, журам сайтар мөрдөх, цэргийн алба хаагчдын ёс суртахуун, албандаа хандах хандлагыг сайжруулахад чухал ач холбогдолтой аж.

Ө.НАСАНТОГТОХ



АЖЛЫН ХЭСЭГ ДАРХАН-УУЛ, ОРХОН АЙМАГТ АЖИЛЛАЖ БАЙНА

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг Дархан-Уул, Орхон аймгуудад байрлах Зэвсэгт хүчний анги, салбарын үйл ажиллагаатай танилцаж байна.

Энэ хүрээнд Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа болоод цаашид хэрхэн ажиллах төлөвлөгөө, боломж нөхцөлтэй танилцав. Тус мод үржүүлгийн газар нь одоогийн байдлаар 2.5 га талбайд шинэс, гацуур, агч, хайлаас, шар хуайс, буйлс зэрэг модыг үрээр, бургас, улиас зэрэг модыг суулгацаар тариалжээ.

Үүний дараа ажлын хэсэг Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа, тариалангийн талбайн ургац хураалттай танилцсан юм. Тус ангийн Эрчимжсэн мал аж ахуй нь үнээний "Грэйфорд" үүлдрийн махны чиглэлийн үхрийн удам угшлыг нь сайжруулах,



махны чиглэлийн үхрийн цөм сүрэг байгуулах үндсэн зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Улаанбаатар-Дархан чиглэлийн

авто замын 4 дүгээр багцын бүтээн байгуулалтын үйл явцтай танилцсан юм. Эл бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний 342 дугаар анги оролцож байгаа бөгөөд 30 ширхэг гүүр хоолой, 25 километр авто замын доод бүтцийн



ажлыг хийж гүйцэтгэн дуусгах шатандаа явж байгаа аж.

Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүн Дархан-Уул аймгийн удирдлагуудтай албан уулзалт хийж зарим асуудлыг шийдвэрлэлээ.

Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 330, 186, 110 болон Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 322 дугаар ротын үйл ажиллагаатай танилцана.

Дэслэгч Т.ИДЭР

"ШҮХЭРЧИН ДАЙЧДЫН ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭВ



2022 оны 9 дүгээр сарын 20-ны шаргал нар дэвссэн намрын сайхан өдөр Зэвсэгт хүчний "Шүхэрчин дайчдын өдөр"-ийг ёслол тэмдэглэлээ.

Эл өдөр Шүхэрчин дайчдын өлгий болсон Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Хужирбулан дахь Сургуулийн төвд тус ангийн 57 жилийн түүхийг бичилцсэн ахмадууд, тус ангийн бие бүрэлдэхүүн, Тусгай хүчний командлал, Цэргийн тагнуулын газрын төлөөлөл хүрэлцэн иржээ.

Тус ангийн Ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл дэд хурандаа Б.Мөнхжаргалын урьж цуглуулсан ахмад настнуудын дунд 084 дүгээр ангийн штабын дарга, захирагчаар ажиллаж байсан чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Батбаяр, тус ангийн анхны шүхэрчдийг араасаа дагуулан шүхэрлэн бууж явсан Шүхрийн спортын мастер ахлагч Ц.Хандсүрэн, анхны салаа, салбарын захирагч нарын нэг ахмад Г.Базарсад, байлдагчаас хурандаа хүртэл тус ангид алба хаасан "шүхрийн" гэх овогтой Н.Баярмагнай, хувцасны нярваар олон жил ажиллаж, ангийн 7

нүүдлийн ачааг таталцаж явсан Ж.Цэндмаа, анги хамт олныхоо нэрийг одоо ч мандуулж яваа Хүндийн өргөлтийн ОУХМ ахмад Ш.Лхагваа, толгойгоор тоосго мөргөх тулааны урлагийг армид анх нутагшуулсан бэлтгэл хурандаа Д.Батбаатар гээд бүгд л түүхэнд нэр мөрөө үлдээсэн хүмүүс хүрэлцэн иржээ.

Энэ үеэр чөлөөнд байгаа ахмад Г.Базарсад, С.Чулуун нарын Хөдөлмөрийн алдрыг тэмдэглэж, цэргийн тэтгэвэрт гарч буй дэд хурандаа Б.Бүрэнзэвсэг, ахмад Н.Алтанбагана нар Байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлэв.

Мөн Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчид ая дууны мялаалга өргөж, шүхэрчид Уулын шүхэр буюу парагидингээр буун баярын мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Бэлтгэл хурандаа Н.Баярмагнайн тасгийн захирагч 1981 оны цэрэг С.Баясгалан, хурандаа Д.Батбаатарын салааны захирагч Г.Базарсад, Шүхрийн спортын мастерууд Ц.Хандсүрэн, Б.Александр, Н.Баярмагнай, дэд хурандаа

Б.Бүрэнзэвсэгийн ээж С.Цэцгээ хүүдээ баяр хүргэж, тус ангийг удирдаж явсан Б.Батбаяр, Д.Батбаатар, Б.Эрхэмбаяр, Ч.Түмэндэмбэрэл, Б.Хаш-Эрдэнэ, Д.Шинэбаяр нар гээд сонин содон хүмүүс уулзалдаж дурсгалын зураг татуулав.

1969 оны 3 дугаар сарын 29-ний өдөр тасгийн дарга Б.Надмид тэргүүтэй 21 түрүүч, байлдагч нар шүхрийн анхны буулт хийсэн байдаг. Тэднээс өдгөө Навааны Сүхбаатар, Далхжавын Жамц нар түүхэн үйл явдлын гэрч болон бидний дунд аж төрж байна. Тэр цагаас хойш цэргийн шүхэрчид шөнийн, усны, модны буултыг хийж шүхэр десантын спорт улам бүр хөгжсөөр байгаа нь энэ билээ.

Хөхрөх уудам тэнгэртээ бид Хүрэн бүргэдийн зоригтой билээ

Хээтэн ногоорох газартаа бид

Хээрийн чонын хийморьтой билээ гэсэн сэтгэлийн андгайтай хүмүүс дээ. Оросын десантынхан "Никто кроме нас!" уриатай.

Эх сурвалж: Ахмад дайчдын "Улаан одхон" сонин

ФОТО АГШИН



G. Bat-Erdene
baagii_photos

ШИЛДЭГ БАЙЛДАГЧДАА БАЯР ХҮРГЭЛЭЭ



2022 оны 9 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд Хил хамгаалах байгууллагаас зохион байгуулсан "Шилдэг хугацаат цэргийн алба хаагч-2022" тэмцээнд Хилийн цэргийн 0130 дугаар ангийн ахлах түрүүч Х.Мягмардорж оролцож 5 дугаар байрт шалгарчээ. Тэрээр

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумаас хугацаат цэргийн албанд татагдсан бөгөөд тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Д.Төмөрбаатар баяр хүргэн Цэргийн штабын хамт олны өмнөөс гарын бэлэг гардуулж амжилт хүслээ.



АЛТАНХАН МӨРДЭС АХМАД ЦОЛ МИНУ

Андгай өргөж, алба хаасан он жилүүдийн гэрч Амжилт алдрын гэгээн мөр туулсан баталгаа Цэргийн цол дундаа мөрдөс дүүрэн цол ахмад Цэмцгэрхэн дүрэмт хувцсаа чимсэн гоёхон цол Эх орон, эгэл түмнийхээ төлөө амиа ч өргөсөн Эрэлхэг баатруудын гавьяа замналтай мөрдөс Төрсөн тэлсэн аавууд минь ахмад дайчид явсан Төр түмнийхээ төлөө зүтгэсэн бахархлууд байсан Амжилт алдрын шатанд хүргэсэн алтан мөрдөс Алдаа онооны дэнсэнд хамт шүүгдсэн цол минь Хатуу бэрх сорил саадыг гэтэлгэсэн мөрдөс минь Халуун бул, залгамж үрсээр өнөржсөн цол минь Энгэр чимсэн эрдэнэс нь гялалзах дүрэмт хувцас Эх орон дуудвал бэлэн гэх" хувцас минь хүлээнэ Тавилан хошууд нь гялалзах алтанхан мөрдөс минь Тавилан ерөөлийн даллагатай цэргийн цол минь

Ахмад Бүүвэйбаатарын МӨНГӨНХУЯГ

Таны сонорт



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



"Соёмбо" сонин



"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)